

САЙНЦАГААН СУМЫН ЗДТГ-ААС ХЭРЭГЖҮҮЛСЭН “САЙНЦАГААН 95” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2019.11.22

Мандалговь хот

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл		
1.	Сайнцагаан 95		Бүтээн байгуулалтыг өрнүүлж дэд бүтэцийг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны гадна өнгө үзэмж тохижилтийн сайжруулах замаар иргэдийн ая тухтай амьдрах орчныг бий болгож Сайнцагаан сумын 95 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр		Улсын болон аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсөв.		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Сайнцагаан сумын ЗДТГазар 2019 онд бүрэн хэрэгжиж дуусна.		
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1. Бүтээн байгуулалт өрнүүлж, дэд бүтцийг сайжруулах, нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах. Зорилт 2. Урлаг, соёл, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулах. Зорилт 3. Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих Зорилт 4. Сайнцагаан сумын 95 жилийн ой тэмдэглэх. Зорилт 5. Хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. Зорилт 6. Шаардлагатай төсөв санхүүг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.		
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	8.126.800		
		Үүнд:	Төсөв (2019 он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	1,984,200	1,984,200	100%
		Багц 2	5.350.000	5.350.000	100%
		Багц 3	792.600	792.600	100%
		Багц 4	-	-	
		Багц 5	-	-	
		Багц 6	-	-	
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Хөтөлбөрийн зорилтуудын биелэлт		

	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Бүтээн байгуулалт хийгдэж орчны тохижилт сайжирсан байна.	• 21 төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулагдаж нийт Улсын төсвийн болон аймаг орон нутгийн ОНХС-ийн 5,5 тэр бум төгрөгөөр бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Урлаг спортын арга хэмжээнүүд зохион байгуулагдсан байх.	• Сангийн яамны анхны сайд Г.Чагдаржавын мэндэлсний 150 жил, сумын 95 жилийн ойг угтаж “САЙНЦАГААН – 95” спортын наадам, сурагчдын дунд урлагын наадам, Сайнцагаан сумын үзэсгэлэнт, түүхэн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудын зурагт ном гаргах зэрэг ажлуудыг амжилттай зохион байгуулж 1000 гаруй иргэнийг хамруулж чадлаа.
	3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 1.Түншлэл арга хэмжээ зохион байуулагдсан байх. 2.Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон үйлчилгээний байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулсан байх.	• Сум хөгжүүлэх сан”-аас зээл авах хүсэлтэй 6 ААН-ын захирал, 46 иргэнийг төсөл боловсруулах арга зүйн, СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын сургалтанд тус тус хамрууллаа. Сургалтаар иргэд сонирхсон төслөө өөрсдөө бичиж, тооцоолж бизнес төлөвлөгөөгөө боловсруулсан нь үр дүнтэй сургалт байлаа. Сургалтанд СХС-аас 1.061.200 төгрөгийг зарцууллаа. • БОАЖЯ-аас санаачлан зохион байгуулсан Зочлох үйлчилгээний чанарыг сайжруулах онол, практикийн сургалтыг 4 хоног зохион байгууллаа. Зөөгч бармены сургалтад 25 хүнийг хамруулж, ур чадвар эзэмшүүлэх сургалтыг ажлын байран дээр дадлагажуулах, харилцаа үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, үйлчилгээндээ орчин цагийн дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлж, үйлчилгээг хурдан шуурхай, ёс зүй, эерэг харилцааг бий болгох, өөрийн ажлын байранд чанарын стандартыг хэрэгжүүлэн ажиллах ур чадваруудыг эзэмшүүлэхэд голлон анхаарлаа. • Говийн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжил, урлаг спортын уралдаан зохион байгуулагдлаа. Ажил мэргэжлийн уралдааны ресторан, зоогийн газрын төрөлд “Сондор” зоогийн газрын тогооч Л.Одгэрэл хүрэл медаль, АЗДТГазрын тогооч О.Нарангарав хүрэл медаль, орчин үеийн монгол хоол төрөлд “Сондор” зоогийн газрын тогооч Л.Одгэрэл мөнгөн медаль, оюутан тогооч төрөлд МСҮТ-ийн оюутан тогооч Г.Отгонбаяр алтан медаль, МСҮТ-ийн оюутан Ц.Нарангэрэл тусгай байр, зөөгч бармены төрөлд “Бүрд” зоогийн газрын зөөгч Мөнгөнцацрал тусгай байр тус тус эзэллээ.
	4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 1. Сайнцагаан сумын 95 жилийн ойг тэмдэглэн	• Сум байгуулагдсаны 95 жилийн ойг аймгийн баяр наадамтай хамтатган тэмдэглэлээ. Баяр наадамд хүчит 128 бөх, 200 гаруй хурдан хүлэг, 70 гаруй шагай харваачид, 80 гаруй сур харваачид оролцлоо. • 2019 оны 11-р сарын 01-ны байдлаар сумын орон нутгийнхаа хөгжилд хувь

	өнгөрүүлэх. 2. Сум орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан, ажил хөдөлмөр нь амжилттай яваа иргэдийг төрийн одон медалиар шагнуулах	нэмрээ оруулсан тэргүүний 67 иргэнийг төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлолт, холбогдох материалыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.
	5-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 1.Тэжээлийн агуулахтай болгох. 2.Тогоогийн хужрыг хашаажуулах. 3.Наран багт мал угаалгын ванн барих. 4.Энгийн уурхайн 8 худгийг засварлах.	• ОНХС-ийн 50.0 сая төг-ийн хөрөнгөөр 150 тн багтаамжтай тэжээлийн нөөцийн агуулахыг “Өгөөмөр бурхант” ХХК барьж ашиглалтанд орууллаа. • Халзан хайрхан иргэдийн бүлэг Далай багийн нутагт байрлах Тогоогийн хужрыг орон нутгийн төсвийн 2,5 сая төгрөгөөр хашаажуулах ажлыг гүйцэтгэлээ. • Энх говийн марал ХХК ОНХС-ийн 8,0 сая төгрөгийн хөрөнгөөр Наран багт мал угаалгын ванн барьж ашиглалтанд орууллаа. • ОНХС-ийн 16.0 сая төгрөгийн хөрөнгөөр энгийн уурхайн 8 худгийг хашаа, худаг засварын “Халзан хайрхан” бүлэг, Б.Пүрэвдорж ахлагчтай игэдийн бүлгүүд засварлах ажлыг гүйцэтгэж комисс хүлээн авлаа. Улсын төсвөөр бэлчээрийн 5 цэгт гүний усны хайгуулын ажлыг гүйцэтгэлээ.
	6-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 1.Шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах. 2.Урлаг, соёл, спортын арга хэмжээ болон баяр наадам тэмдэглэхэд аж ахуй нэгж, иргэдтэй хамтран ажиллах	• Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 2020 онд Сайнцагаан суманд 2,5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтын ажлыг тусгуулахаар төлөвлөж, бүлгийн хурлаар дэмжигдэж, аймгийн ИТХ-аар батлуулна. • Сум байгуулагдсаны 95 жилийн ойн баяр наадмын бай шагналын 4 насны айргийн 5 морьдын бай 4,6 сая төгрөгийг хөдөөгийн 4 багийн малчид ивээн тэтгэлээ. Мөн Сайнцагаан хоинины омог батлуулах ажилд малчид 3,0 сая төгрөгний хандив өглөө.
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	• Тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр Хотын төвийн явган хүний зам, талбайн өнгө үзэмж сайжирч нийтийн орон сууцнуудын гадна тохижилт хийгдэж иргэдийн ая тухтай орчин нөхцөлд оршин суух таатай байдал бий болсон. Үйлчилгээний байгууллагын ажилчдын соёл хандлага сайжирсан. Хөдөөгийн малчидад чиглэсэн тэдний тулгамдсан асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж чадсан. Сайнцагаан сумын 95 жилийн ойн баяр наадмыг өргөн дэлгэр сайхан тэмдэглэн өнгөрүүлсэн. • Зарим төлөвлөгдсөн ажлууд цаг үеийн асуудаас болж зохион байгуулалтын ажил

		нь хойшлогдсон, цуцлагдсан зэрэг дутагдалтай анхаарал зүйлсүүд байлаа.						
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ							
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
		84,7%	85,7 %	56 %	100 %	100 %	66,6 %	100 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (Сумын ИТХ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						
		100 %						

САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР